

*3. Тамир - Тагнуулын академийн магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч
В.Пүрэвбаасан -ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн Хилийн албты удирдлага, стратегийн
профессорын багийн дэд профессор. хурандаа*

АГААРЫН ХӨЛӨГ БАРЬЦААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЗАРИМ АСУУДАЛ

Хураангуй: Энэ өгүүлэлд терроризмтой тэмцэх ажиллагаа тэр дундаа агаарын терроризм буюу агаарын хөлөг барьцаалах, хулгайлах гэмт хэрэг гэж $k > u$ болох, даяаршлын нөхцөлд улс орнууд, түүний дотор манай улс агаарын хөлөг барьцаалах, хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх арга, ажиллагаа, тактикаа хэрхэн тодорхойлох, тус төрлөгш гэмт хэргийн үүсэж болох эрсдлийн талаар өгүүлэв.

Түлхүүр үг: Агаарын терроризм, агаарын хөлөг барьцаалах, хулгайлах гэмт хэрэг. Нисэх буудлын аюулгүй байдал, агаарын зам, дамжин өнгөрөх нислэг.

Орчин үед даяаршлын үйл явц өсөн нэмэгдсээр байгаа нь Монгол Улсын хөгжилд эерэг болон сөрөг нөлөө үзүүлсээр байна. Дэлхий нийтийг хамарсан аялал жуулчлал, соёлын харилцааны хурдацтай хөгжил, олон улсын эдийн засгийн интеграци, үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагаа, тэдгээрийн хөрөнгө оруулалтыг татах эрмэлзэл нь манай улсын төр засгийн удирдлагуудын нэн тэргүүний зорилт болоод байгаа энэ цаг үед улс орныхоо аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын өмнө асар олон сорилтуудтай нүүр тулж байна. Үүний дотор олон улсын терроризмын аюул занал тэр дундаа агаарын терроризм буюу агаарын хөлөг барьцаалах, хулгайлах гэмт хэрэг билээ.

Аюулгүй байдлын хүчин зүйлс хурдацтай өөрчлөгдөж байгаа өнөөгийн орчинд үндэсний ашиг сонирхлоо тууштай хамгаалах, хүн ам, ард иргэдийнхээ амьдрах аюулгүй, таатай орчинг бүрдүүлэх, эдийн засгийн, гадаадын хөрөнгө оруулалтыг татах гадаад болон дотоод таатай нөхцөлийг бүрдүүлэхэд төрийн болоод бусад тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан үйл ажиллагаа, уялдаа холбоо чухал үүрэгтэй.

“Энхийг сахиулах” гэдэг үг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд байдаггүй. Гэхдээ сүүлийн долоон жилийн туршид “олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах” гэсэн бидний хамтын чадавх ихэвчлэн дэлхийн өнцөг булан бүрт дайны хөлд нэрвэгдсэн халуун шугам дээр амь биеэ үл хайрлан зүтгэх зоригт НҮБ-ын энхийг сахиулагчдаас хамаарч ирсэн

билээ” НҮБ-ын энхийг сахиулах дээд хэмжээний уулзалтын үеэр Ерөнхийлөгч Барак Обамагийн хэлсэн үг¹

Манай улс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд анхны 2 цэргийн ажиглагч офицерыг 2002 онд Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад явагдсан энхийг сахиулах ажиллагаанд илгээснээс эхэлсэн түүхтэй. “Үүнээс хойш 14 жилийн хугацаанд дэлхий нийтэд явагдсан НҮБ-ын 11 энхийг сахиулах ажиллагаанд нийтдээ 6700 гаруй цэргийн алба хаагч, Ирак, Косово, Афганистан Улсад явагдсан эвслийн цэргийн ажиллагаанд нийт 4500 орчим цэргийн алба хаагч, нийтдээ давхардсан тоогоор 13 000 орчим цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэсэн бол яг одоо 1200 орчим цэргийн алба хаагч ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж байна.”^{1 2}

Дээрх тоо баримтаас харахад дэлхий нийтэд хууль бус үйл ажиллагаа явуулж буй террорист байгууллагуудын өмнө манай улс: “Дэлхий нийтийн терроризмтой тэмцэх дайн”-д идэвхтэй оролцож байгаа явдал нь тэдгээрийн сонирхлыг тодорхой хэмжээгээр татах эрсдлийг бий болгож байна. Учир юу гэвэл олон улсын терроризмын хандлага, алан хядах бүлэглэлүүдийн үйл ажиллагаа өдрөөс өдөрт хэрэглэгчдийнхээ тоо, хүрээг тэлж буй нийгмийн сүлжээгээр дамжуулж элсүүлэх, урвуулах, уриалга, суртал ухуулгын үйл ажиллагаа явуулж ирсэн талбар нь аажимдаа сурган хүмүүжүүлэх, алан хядагчдыг бэлтгэж, сургах алсын зайн /онлайн/ сургалтын зам суваг болон хувирч байна. Үүний тод илрэл нь “Исламын улс” бүлэглэлийн “Халифат” улс байгуулах мөрөөдөл нь үгүй болж, үүнтэй холбоотойгоор террорист үйл ажиллагаагаа илүү өргөн хүрээнд явуулахыг эрмэлзэж байгаа ба тус бүлэглэл газар нутгаа алдсанахаа хариуг авахаар Ирак, Сири дэх төвлөрсөн цэгээсээ Ливи, Египет, Йемен, Алжир, Нигер, Афганистан, Пакистан, ОХУ-ын Кавказ болон Зүүн Ази дахь кибер орон зайд үйл ажиллагаагаа идэвхжүүлэхэд анхаарч эхэллээ. “Исламын улс” бүлэглэлийн “Аль-Хаят” хэвлэл мэдээллийн албанаас 2017 оны 12 дугаар сард өөрийн дэмжигчиддээ хандан “...тэвчээртэй хүлээ, ялалтад хүрэх болно...” гэсэн суртал ухуулгыг видео бичлэгээр тараасан³ явдал юм.

Олон улсын терроризмын чиг хандлага, үйл ажиллагаа, арга хэрэгсэл, халдлагын төрлүүд нь дэлхий нийтийн хөгжлийн үе шат бүрийг “Уүүдэр” мэт даган хувьсан өөрчлөгдсөөр байна. Улам бүр даяаршиж , интеграцлагдаж,

¹ <https://en.usembassy.gov/mn/remarks-president-obama-u-n-peacekeeping-summit/>

² <http://www.mod.gov.mn/index.php?com=news&id=1098>. НҮБ-ЫН ЦЭРГИЙГ МОНГОЛЧУУД УДИРДАХ ЦАГ ОЙРХОН. 2016 оны 04 сарын 26-ны өдрийн Батлан хамгаалахын сайд Ц.Цолмонгийн мэндчилгээ.

³ <http://gia.gov.mn/13/item/68>, олон улсын терроризмын сүүлийн үеийн нөхцөл байдлын мэдээ

цахимжаж буй энэ цаг үед алан хядах үйл ажиллагааны нэг төрөл болох агаарын терроризмын аюул занал, түүний хор хөнөөл маш аюултай бөгөөд эмзэг сэдэв хэвээр байна. Учир нь дэлхий нэртэй судлаач, шинжээчдийн үзэж байгаагаар бол “глобалчлал”-ын хамгийн сул, эмзэг талыг дэлхий дээр оршин тогтнож буй улс, үндэстнүүдийн бусдаараа ялгарах, үндсэрхэг үзлийг дэвэргэх гол шалтгаан болж байна хэмээн үздэг. Тэгвэл энэ эмзэг “цэг”-ийг олон улсын алан хядах байгууллагууд өөрсдийнхөө зорилго, зорилтоо хэрэгжүүлэх, улс орнуудын дипломат харилцаа, үндэстэн хоорондыг хагалан бутаргах, мөргөлдөөн, зөрчилдөөнийг дэвэргэхэд чиглэсэн байдаг.

Манай Монгол Улсын хувьд газар зүйн байршлаарай хоёр “том” гүрний дунд оршин байдаг. Энэ нь нэг талдаа давуу тал мэт боловч нөгөө талдаа сөрөг дагавартай билээ. Тус хоёр гүрэн нь дотоод доо салан тусгаарлах үзэл, алан хядах үйл ажиллагааны идэвхжилттэй, голомтууд ихтэй байдаг улс орнууд юм. Иймдээ ч дээрх алан хядагчдын үйл ажиллагаагаа явуулах, хорлон сүйтгэх ажиллагаагаа явуулах, дэлхий нийтийн анхаарлыг татах, улс орон - үндэстэн хоорондын зөрчилдөөнийг дэвэргэж болох эмзэг цэг нь агаарын хөлөг барьцаалах, хулгайлах гэмт явдал юм.

Манай “өмнөд” хөрш болох БНХАУ-ын хувьд жишээ татаж үзэхэд 2012 оны 06 сарын 29-ний өдөр, “Тианжин Эйрлайнс” иргэний агаарын компанийн Хотан хотоос Өрөмч хот руу нислэг үйлдэх гэж байсан GS 7554 дугаартай Embraer ERJ-190 агаарын хөлгийг барьцаалах, хулгайлах оролдого хийгдсэн байна. Тус хэргийг 20-36 насны зургаан уйгар гаралтай хятад улсын иргэд үйлдсэн ба тэдгээр нь “Дорнод Туркестаны Исламын Хөдөлгөөн” хэмээх орон нутгийн хууль бус террорист бүлэглэлийн гишүүд байсан аж. Гэсэн хэдий ч тухайн нислэгийн үед зорчиж явсан 6 цагдаагийн албан хаагч, иргэний агаарын компанийн хоёр хамгаалалтын албаны ажилтнууд болон зорчигчдын тусламжтайгаар дээрх гэмт хэрэг үйлдэгдэхээс сэргийлж чадсан байна. Мөн 2018 он 04 сарын 15-ны өдөр “Эйр Чайна” компанийн нисэх онгоц Хэнань мужийн Чэнжоу хотод ослын буулт үйлдсэн байдаг. Тус нислэгээр үйлчлүүлж явсан зорчигч онгоцны үйлчлэгчийг барьцаалахын тулд үзгэн бал ашиглаж шархдуулсан ба дээрх тохиолдол зорчигч нарын хэсэгт үйлдэгдсэн даруйд нисэх онгоцны ахмад онгоцыг яаралтай газардуулах арга хэмжээ авч ослын буулт хийжээ. Тус хэргийг үйлдэхээр завдсан этгээд тэр даруй хууль сахиулах байгууллагынханд саатуулагдсан байна.¹

Дээрх хоёр жишээнээс үзэхэд манай улсын “мөнхийн” хэмээн нэрийддэг хоёр хөрш орон маань дотоод доо алан хядах. салан тусгаарлах үйл

ажиллагааны идэвхжилттэй, тодорхой бүс нутгуудтай улс орнууд юм. Манай Монгол Улсын геополитик, газар зүйн байрлал нь тусгаар тогтнол, бүрэн эрхт, хилийн халдашгүй дархан байдал талаасаа аюулгүй, бат найдвартай мэт харагдах боловч нөгөө талдаа олон улсын терроризм тэр дундаа энэ хоёр орны дотоодын салан тусгаарлах, алан хядах бүлэглэлүүдийн хорлон сүйтгэх ажиллагааны золиос болох эрсдэл тун өндөр байна. Манай орны хувд экспортын 87.8%, импортын 33,7%-ийг бараа, бүтээгдэхүүнийг БНХАУ-аас, импортын 29,58%-ийг ОХУ-аас тэр дундаа эрчим хүч, түлш, газрын тосны бүтээгдэхүүнхээ 90% гаруй хувийг авдаг, манай улсын уул уурхайн салбарын орлогыг бүрдүүлдэг нүүрс 25,61%, зэс 50%-ийг эзлэх жин хувьтай' байгаа энэ үед хорш орнуудтайгаа харилцах харилцаанд харшилж болохоор гэмт үйлдэл, хорлон сүйтгэх ажиллагааг олж илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох нь бидний хуулиар хүлэсэн үүрэг.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр агаарын замаар дамжин өнгөрөх нислэгийн тоо 2017 оны 11 сарын 26-ны өдөр 100 мянгад хүрсэн бөгөөд тус онд 110-115 мянган олон улсын нислэгийн дамжин өнгөрөлт хийнэ гэсэн тооцоо судалгаа гаргажээ.^{1 2} Өнөөдрийн байдлаар манай улсын агаарын орон зай. замыг 87 улсын 180 гаруй компани ашиглаж, дамжин өнгөрөлтийн нислэг гүйцэтгэдэг. Энэ он дуустал хоёр сар гаруйн хугацаанд 10 мянга гаруй нислэг өнгөрүүлэх тооцоо байгаа бөгөөд Монгол Улсад орох навигацийн орлого 50 тэрбум төгрөгөөр нэмэгдэх юм.³ Манай улс навигацийн үйлчилгээний орлогоос 2011 онд улсын төсөвт 40,8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн бол 2015 онд 98.5 тэрбум, 2016 онд 130 гаруй тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.⁴ Монгол Улсын Иргэний нисэх ерөнхий газар нь 2011 онд Монгол Улсын агаарын зайд нислэгийн багасгасан босоо зайчлал буюу тухайн үед 500 метрээр онгоц зөрүүлдэг байсныг 300 метр болгож багасгасан юм. Ингэснээр агаарын зайн багтаамж 40 хувиар нэмэгдсэн. 2012 онд бид Монгол дахь агаарын зайг хянадаг, нислэг хөдөлгөөний удирдлагын үйлчилгээнд бодит ажиглалтын систем буюу “локатор” нэвтрүүлсэн. Онгоц хоорондын тууш зайчлал 10 минут буюу 150 км байсныг 30 км хүртэл багасгаснаар Монгол Улсын агаарын зайн багтаамжийг тав дахин ихэсгэсэн. Ингэснээр манай орны дээгүүр нисэн өнгөрөх онгоцны тоог нэмэгдүүлэх нөхцөл бололцоог бий болгож байна.

Дээрх үзүүлэлтүүд нь манай улсын төсөвт асар их хэмжээний мөнгөн дүнг төвлөрүүлж байгаа нь эерэг талтай ч нөгөө талдаа дамжин өнгөрөх

¹ Д.Тунгалаг “Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын онол, практикийн зарим асуудал” ном, 2015 он

² <http://montsame.mn/mn/read/73559>

³ <http://www.medeer.mn/main.php?eid=100356>

⁴ <https://ikon.nin/n/153e>

нислэгийн тоо, агаарын замын урсгал нэмэгдэхийн хэрээр манай орны аль ч өнцөг булан бүрт буюу хот, хөдөө, орон нутгийн гэж ялгалгүй нисэх буудлуудад нислэг үйлдэж буй агаарын хөлөг ослын буулт хийх, газардах явдлыг нэмэгдүүлж байна гэсэн үг. Тэр дундаа олон улсын террорист бүлэглэл эсвэл хөрш орнуудын маань алан хядах, салан тусгаарлах бүлэглэлийн гишүүдийн оролцоотойгоор үйлдэгдсэн агаарын хөлөг барьцаалах, хулгайлах гэмт хэрэг.

Бид агаарын хөлөг барьцаалах, хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд бэлэн уу?

Хүн төрөлхтөн агаарын хөлөг буюу нисэх онгоцыг бүтээж, ашиглаж эрсэнээс хойш 100 гаруй жилийн нүүрийг үзэж байгаа хэдий ч хүмүүс бидний өдөр тутмын үйл ажиллагаа тэр дундаа бизнес, аялал жуулчлалын шугамаар ашигладаг, дэлхийд хамгийн аюулгүйд тооцогддог¹, тээврийн хэрэгсэл болон хувирчээ. "Олон улсын иргэний агаарын тээврийн холбоо" /IATA/-ийн гаргасан судалгаагаар дэлхий даяар жилд дундажаар 3,8 тэрбум хүн нисэх онгоцоор үйлчлүүлдэг байна. Энэ тоо жил бүр нэмэгдэж байгаа бөгөөд 2036 он гэхэд дээрх тоо 7,8 тэрбумд хүрнэ хэмээн таамаг дэвшүүлсэн байдаг.^{1,2}

Дэлхий нийт олон улсын терроризмын халдлагуудын төрлийн талаар, алан хядах үйл ажиллагааны талаар өдөр бүр сонин хэвлэл, телевиз-радио, нийгмийн сүлжээгээр дамжуулан олж, мэдэж, сонсдог. Тэр дундаа агаарын терроризм буюу агаарын хөлөг барьцаалах, хулгайлах гэмт хэргийн талаар тогтсон уламжлалт ойлголттой явсаар ирсэн. Гэтэл 2001 оны 09 сарын 11-ны өдрийн халдлага олон нийтэд бүрэлдэн бий болоод байсан тэрхүү ойлголтыг тэр чигт нь эргүүлсэн гэхэд болно. Түүхэндээ агаарын хөлөг барьцаалах, хулгайлах гэмт хэрэг үйлдэгч нар нь дийлэнхи тохиолдолд барьцааны мөнгө шаардах эсвэл улс төрийн тэрс үзэл болон алах хядах үйл ажиллагаанд сэжиглэгдэж, оролцсон этгээдүүдийг хоригдож буй шоронгоос нь суллахыг тулган шаарддаг чиг хандлагатай байв.³ Дэлхий дахинд "9/11" /nine-eleven/ гэдэг үг бараг агаарын терроризм гэдэг үгний тайлбартай дүйцэхүйц хэмжээнд ойлгогддог болжээ.

Дэлхийн улс орнууд дээрх төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд үндэсний буюу өөрсдийн аргачлалыг бий болгохоор зорин ажилласаар байгаа. Гэсэн хэдий ч олон улсын терроризм, түүнтэй тэмцэх ажиллагаа бол цор ганц, бие даасан улс эсвэл байгууллагын ажил биш юм, XXI зуунд аюулын харанга

¹ <https://korrespondent.net/lifestyle/travel/1579645-IO-faktov-podtverzhdayushchih-cto-samolet-samyj-bezopasnyj-sposob-puteshestvovat-po-miru>

² <https://www.iata.org>

О.И.Губарев "Тайны воздушного терроризма", 2002.

дэлдэх болсон, түргэн хувьсах чадамжтай. техник-технологийн дэвшлийг даган дасан зохицох чадвартай энэ “тахал”-тай тэмцэхийн тулд хууль сахиулах, тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа нэн чухал. Олон улсын практикт дээрх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд голлох үүргийг нисэх буудлуудын аюулгүй байдал, хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэдэг алба, нэгжээс ихээхэн хамаардаг болох нь нэгэнт тодорхой болсон. Иймд манай улсын хувьд “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Аюулгүй байдал, хамгаалалтын алба дээрх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Тус байгууллага нь анх “Олон улсын иргэний нисэхийн” тухай конвенц буюу “1944 оны Чикагогийн конвенц”-ийн стандарт, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх зорилгоор “Чингис хаан” ОУНБ-ын Аюулгүй байдал, хамгаалалтын албыг ИАТУГ-ын даргын 1996 оны 03 сарын 20-ны өдрийн 218-р тушаалаар зохион байгуулсан байдаг. Тус алба нь аюулгүйн үзлэгийн хэсэг, харуул хамгаалалтын хэсгээс бүрдэж үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд нисэх онгоцны буудлын барилга, түүний орчин, нислэгт гарч буй онгоцны аюулгүй байдлыг хангах, тэдгээрийг хөндлөнгийн хууль бус халдлагаас хамгаалах зорилгоор нисэх багийн гипгүүд, зорчигчид болон хамгаалагдсан ба хориотой бүсэд нэвтэрч буй хүмүүсийн бие, гар тээш, ачаа, тээврийн хэрэгсэлд үзлэг хийж, тэсэрч дэлбэрэх зүйл бөмбөг, буу зэвсэг, зэвсэг болгон ашиглаж болох бусад аюулгүй байдлын хориотой эд зүйлсийг авч орохоос урьдчилан сэргийлэх үзлэгийг хийн, нисэхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг явуулж иржээ. Уг алба нь иргэний нисэхэд гарч болзошгүй террорист үйл ажиллагаа, агаарын хөлгийг барьцаалах, булаан зугтах, агаарын хөлөг болон нисэх буудлын байшин барилга түүний орчин, тоног төхөөрөмжийг хорлон сүйтгэх зорилгоор тэсрэх бөмбөгөөр заналхийлэх зэрэг аюулаас урьдчилан сэргийлэх зорилготойгоор ажиллаж байна. Нисэх буудал болон периметрийн хашааг эргэн тойрсон 17 цэгт харуулын пост бий болгон 24 цагийн байнгын харуул, жижүүрийг дүрэм журмын дагуу ажиллуулж, нисэхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналтын төв телекамерийн системийг 106 цэгт 16 дэлгэц ашиглан аюулгүйн хяналт тавьж. 6 нэвтрэх цэгт автомат цоож бүхий бүртгэлийн системийг ашиглан ажиллаж байна. Олон улсад өрнөж буй террорист үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, үзлэгийг улам чанаржуулах үүднээс “Нохой хөтлөгч - зохицуулагч” нарыг ашиглан нисэх буудлын хонгил, ачаа тээшинд үзлэг хийж байна.¹

¹ <http://airport.gov.nin/pages/taniltsuulga/ABHA/>

Агаарын хөлөг барьцаалах, хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд манай улс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй билээ. Үүнд:

- Хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгож /нэр томьёо. зүйл заалт/-ыг дэлхийн жишигт хүргэх
- Хууль сахиулах, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд болон бусад төрийн, төрийн бус байгууллагуудын харилцан, уялдаатай ажиллагааг төлөвшүүлж, хэвшүүлэх
- Терроризм, алан хядах үйл ажиллагааг судалдаг судалгаа шинжилгээний хүрээлэн байгуулах
- Барьцаалагч нартай яриа. хэлэлцээр явуулах чадамжтай албан хаагчдыг бэлтгэн сургах, тусдаа алба байгуулах
- Олон улсын хэмжээнд ашиглагдаж буй агаарын хөлгүүдийн бүдүүвч зургийн сан бий болгох эрэг болно.

Дүгнэлт

Өнөө цагт олон улсын тогтолцоо хурдтай өөрчлөгдөн шинэчлэгдэж, даяаршлын үйл явцад дэлхий дахинд бүрэлдэн тогтсон бүх талын харилцаа, хамтын ажиллагаа нь улс гүрнүүдийн нийгэм, эдийн засаг, улс төрийн бодлогоо хэрэгжүүлэхэд харилцан хамааралтай болгож, хүмүүс хоорондын, үндэстэн хоорондын харилцааны үндсэн хэлбэр болж байна. Иймд олон улсын тавцанд Монгол Улсынхаа нэрийг гаргах, өөрийнхөө улсыг сурталчлах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хөрш орнуудтайгаа харилцах харилцаанд асар хүчтэй нөлөө үзүүлж болохуйц хүчин зүйл бол олон улсын терроризмын аюул занал юм. Тэр дундаа агаарын терроризм буюу агаарын хөлөг барьцаалах, хулгайлах гэмт хэрэг. Дэлхийд иргэний агаарын тээврээр үйлчлүүлэх хүмүүсийн тоо цаг, минут бүрээр өсөн нэмэгдэж, манай улсыг зорин ирэх жуулчдын тоо жилээс жилд нэмэгдэж, манай агаарын замаар дамжин өнгөрөх нислэгийн тоо өсөж байгаа явдал нь дээрх төрлийн гэмт хэргийг гарахгүй гэсэн баталгаа болохгүй.

Монгол Улс НҮБ-ын болон бусад олон улсын байгууллагуудын зүгээс энхийг сахиулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, дэмжлэг үзүүлж байгаа нь олон улсын түвшинд манай орны нэр хүндийг өргөх, дэлхий нийтэд үнэлэгдэх зэрэг олон эерэг талтай хэдий ч тус энхийг сахиулах үйл ажиллагаа явагдаж байгаа бус нутаг, улс орнуудад нь олон улсын алан хядах бүлэглэлүүд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байдаг. Бид өөрсдөө ч анзаарахгүйгээр тэдгээрийн уур хилэнг хүргэж анхаарлыг нь татсаар байна. Манай орны хувьд зөвхөн хоёр улстай хил залгаа оршин байдаг улс. Дээр дурдсанчлан тус хоёр улс нь дотоодын салан тусгаарлах, алан хядах бүлэглэлүүдийн идэвхжилттэй, голомтуудтай орнууд юм. Иймдээ ч тэдгээртэй тэмцэх арга, ажиллагааг боловсронгуй болгох, үр дүнтэй болгохын тулд ШХАБ хэмээх байгууллагыг

байгуулж, эгнээндээ Төв Ази, Зүүн Өмнөд, Өмнөд Азийн хэд. хэдэн улсыг нэгтгээд байна. Олон улсын терроризм, түүний хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй шинж чанар. дасан зохицох чадвартай энэ гэмт хэрэгтэй дэлхий нийт, улс орнууд хамтын хүчээр л тэмцэх боломжтой. Иймд манай улс дээрх төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга ажиллагааг бусад улс орнуудын туршлага, арга тактикаас суралцаж, өөрийн улсын онцлогт тохиролуулан, нутагшуулах нь нэн чухал билээ.

Ашигласан эх сурвалж:

1. http://airport.gov.mn/pages/taniltsuulga_ABHA/
2. <https://www.iata.org>
3. О.И.Губарёв “Тайны воздушного терроризма”, 2002
4. А.И.Гушер Проблема терроризма на рубеже нового тысячелетия новой эры человечества. - М, 2002.
5. Е.П. Кожушко Современный терроризм: анализ основных направлений. - Минск: Харвест, 2000
6. <https://korrespondent.net/lifestyle/travel/1579645-10-faktov-podtverzhдавushchih-что-samoleт-samvi-bezопасnvi-sposob-puteshestvovat-po-miru>
7. <https://www.foxnews.com/world/china-plane-hijacking-foiled-in-west-6-detained>
8. <http://www.globaltimes.cn/content/1097975.shtml>
9. Д.Тунгалаг “Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын онол, практикийн зарим асуудал” ном, 2015 он
10. <http://gia.gov.mn/13/item/68>, ОЛОН УЛСЫН ТЕРРОРИЗМЫН СҮҮЛИЙН ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ
11. <https://en.usembassy.gov/mn/remarks-president-obama-u-n-peacekeeping-summit/>
12. <http://www.mod.gov.mn/index.php?com=news&id=1098>. НҮБ-ЫН ЦЭРГИЙГ МОНГОЛЧУУД УДИРДАХ ЦАГ ОЙРХОН. 2016 оны 04 сарын 26-ны өдрийн Батлан хамгаалахын сайд Ц.Цолмонгийн мэндчилгээ.
13. <http://montsame.mn/mn/read/73559>